



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Залуучуудын гудамж 01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.06.09 № 9/1311
танай _____-ны № _____-т

ГАЛШАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ЭНХЧУЛУУН ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 20-оос 2025 оны 05 дугаар сарын 24-ны хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

Сумын Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын ИТХ-аар, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргын 2025 оны А/48 дугаар захирамжаар баталсан байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс сумдын Засаг даргын Тамгын газарт хамааралтай зорилт арга хэмжээг бүрэн тусгаагүй, дугаарлалтын алдаатай, зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчгүй тодорхойлсон. Хэрэгжих хугацаа алдаатай буюу 2025-2028 он гэж төлөвлөсөн боловч 4 жилээр задалж төлөвлөхдөө зөвхөн 2025 онд хэрэгжүүлэх гэх мэтээр хүрэх түвшинг тодорхойлсон.

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулаагүй. Ихэнх арга хэмжээний суурь түвшин байхгүй, шалгуур үзүүлэлтийг арга хэмжээ, хүрэх түвшинтэй уялдаагүй буюу гүйцэтгэлийн хувиар гэж төлөвлөсөн ба хариуцах нэгж хэсгийг алдаатай төлөвлөсөн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зорилт, арга хэмжээ болгон задлаагүй шууд хуулж тавьсан. Төлөвлөгөөний загвар алдаатай,

231060358

албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд зорилт, арга хэмжээ төлөвлөөгүй зэрэг нийтлэг алдаа байна.

Төсөвт байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө сумын Засаг даргын даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн болон хамтран хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг бүрэн тусгах, хэрэгжүүлэх хугацааг улирлаар төлөвлөх шаардлагатай.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог жил бүр шинэчлэн баталдаг. Төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтан мэдээллээ Салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн. Эрүүл мэндийн шалтгаанаар Төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан нийгмийн бодлогын мэргэжилтэн Э.Басбиш нь 2024 оны 11 дүгээр сарын 21-ний Б/38 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалтаар төрийн албанаас чөлөөлсөн бөгөөд 2025 оны 04 дүгээр сард Төрийн албаны нөөцөд бүртгэлгүй иргэнийг Нийгмийн бодлогын мэргэжилтнээр томилсон. Албан тушаалын тодорхойлолт байхгүй. Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Б.Мөнхбатыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс санал болгоогүй 2025 оны 03 дугаар сарын 12-нд А/10 дугаар тушаалаар томилсон байна. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/56 тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 46.2.4 дэх заалтаар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн Б.Мөнхтөрийг Галшар сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/17 тушаалаар Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнээр эргүүлэн томилсон. Төрийн албаны тухай хууль зөрчсөн томилгоо байсан.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Мөнх-Оргилын хувийн хэрэг байхгүй. Бусад төсөвт байгууллагын дарга нар хувийн хэрэг бүрдүүлэлт дээр анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт нь зарим албан хаагчийн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэнийг нотлох баримт бичиг, тусгай шалгалт өгч Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн тогтоол болон Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг, сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан эсэх нь тодорхойгүй албан бичиг байхгүй, албан тушаалын тодорхойлолт байхгүй, албан тушаалын картыг бүрэн гүйцэд хөтлөөгүй зэрэг дутагдал байна.

Төрийн албаны хуульд нийцсэн томилгоо хийх, хувийн хэргийн бүрдүүлэлт, албан тушаалын картыг зөв хөтлөх зэрэг анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээг бүрэн тусгах (суурь түвшин, хүрэх түвшингийн тоон үзүүлэлтийг сумын хэмжээнд тооцон төлөвлөх)

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт тус бүрийг задалж арга хэмжээ болгон тусгах

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар буюу батлагдсан загварын дагуу тус тус төлөвлөх (сумын Соёлын төв анхаарах)

4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

5.Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, тайланг хэн хариуцах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

6.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

7.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг төрийн жинхэнэ албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задалж боловсруулах /албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах/

8.Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчилсан байдлаар оновчтой тодорхойлох

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1.Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлахгүй бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын дарга батлахгүй байх. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэж орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчлөх

2.Төсөвт байгууллагын дарга нарын хувийн хэргийг бүрдүүлж, баяжуулалт хийх.

3.Төрийн албаны тухай хуулийн дагуу хуульд нийцсэн томилгоо хийх.

4.Албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулахад сэдэлжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах.

5.Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан тухайн байгууллагын албан хаагчаар албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх.

6.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх. Мөн ажилд томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн тушаал, захирамж болон тушаал, АТГ-ын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай албан бичгийг хувийн хэрэгт хийх.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1.Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлахгүй бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын дарга батлахгүй байх. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэж орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчлөх

2.Төсөвт байгууллагын дарга нарын хувийн хэргийг бүрдүүлж, баяжуулалт хийх.

3.Төрийн албаны тухай хуулийн дагуу хуульд нийцсэн томилгоо хийх.

4.Албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулахад сэдэлжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах.

5.Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан тухайн байгууллагын албан хаагчаар албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх.

6.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх. Мөн ажилд томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн тушаал, захирамж болон тушаал, АТГ-ын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай албан бичгийг хувийн хэрэгт хийх.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН